

Монос Хүнс ХК-ийн 2023 оны санхүү, үйл ажиллагааны тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт

Монос Хүнс ХК-ийн санхүү болон үйл ажиллагааны дүгнэлт, 2023 оны зорилтын биелэлтийн талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Монос Хүнс ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Монос Хүнс ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2023 онд компанийг удирдлагаар хангахдаа сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгон, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, үүрэг зөвлөмж, төлөвлөгөөт зорилтуудыг хэрэгжүүлэн, тайлант хугацаанд тогтмол хуралдаж компанийн үйл ажиллагаанд нийт 38 үүрэг зөвлөмж өгснөөс 94%-ийн биелэлттэй байна.

Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, оролцогч талуудаас засаглалын хувьд чухалчлан авч үздэг тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилт, байгаль орчин, нийгэм, засаглалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх “MFC Green foot print” төслийг 2022 оноос санаачлан хэрэгжүүлж, хараат бус хөндлөнгийн байгууллагаар байгаль орчин нийгмийн засаглалын үнэлгээг гүйцэтгүүлж үйл ажиллагаандаа тайлагнаж эхэлсэн нь томоохон амжилт байлаа.

Монгол эрчүүдийн дундаж насжилт, эрүүл мэндийн асуудлыг хөндсөн “Хэнэгтэй Монгол эр хүн” төсөл, “Үрсээ устай үлдээ” аян, жил бүр эмнэлгийн хүүхдийн өрөө тохижуулах санаачлага, хэрэглэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг хамт олны санаачлагаар хэрэгжүүлж буй нийгмийн нөлөөлөл, манлайллын ажлуудад ТУЗ-ийн зүгээс талархалтай байгааг дурдах нь зүйтэй юм.

2023 оны голлох төсөл болох MFC 2.0-ийн төслийн хүрээнд эрүүл мэндийн шингэн хүнс болон хуурай хүнсний үйлдвэрлэл, чанарын хяналт баталгаажуулалт, инженер техникийн үйл ажиллагааг нэгдсэн байршилд төвлөрүүлж, шингэн хүнсний үйлдвэрийн хүчин чадлыг 2.5 дахин нэмэгдүүлэх, автоматжуулсан технологи, ногоон шалгуурыг хангахуйц тоног төхөөрөмжийн сонголт бүхий, 6000 мкв талбайтай эрүүл мэндийн нэгдсэн үйлдвэрээ ашиглалтад оруулж эхлээд байна.

Түүнчлэн өнгөрсөн 10 жилийн үйл ажиллагааны өсөлт хөгжил, гадаад дотоод орчны өөрчлөлт чиг хандлага, ирээдүйн бизнесийн цар хүрээ, стратеги чиглэлд нийцүүлэн компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг шинэчлэн баталсныг та бүхэнд танилцууллаа.

Монос Хүнс ХК-ийн хамт олон нь 2023 онд 31.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 3.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж төлөвлөсөн зорилгоо 95%-аар биелүүлж, өмнөх оноос борлуулалтын орлогоо 12%-аар, цэвэр ашгаа 9%-иар өсгөж ажилласан, үндсэн үйл ажиллагааг тогтвортой үр дүнтэй удирдахын зэрэгцээ компанийн ойрын ирээдүйд өсөлт гаргах чухал төсөл MFC 2.0 төслийг 93%-ийн биелэлттэй хэрэгжүүлсэн, Киргиз, Австрали улсад бүтээгдэхүүнээ бүртгүүлж экспортын тэлэлтийг хийх суурь бэлтгэлийг хангаж үр дүн ажилласан зэргийг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс “САЙН” ажилласан хэмээн дүгнэж байна.

Компани нь цаашдын үйл ажиллагаандаа дараах чиглэлийг анхаарахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс зөвлөж байна. Үүнд:

- MFC 2.0 төслийн хаалтыг хийж үйлдвэрийг бүрэн ашиглаж эхлэх, үйлдвэрийн хүчин чадлаас хамаарсан тасалдлыг бууруулах
- ТУЗ-аар хэлэлцүүлж баталсан 2024 оны бизнес төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах
- Үйл ажиллагаандаа хэвшүүлсэн сайн засаглалын зарчим, нийгмийн нөлөөллийн ажлуудаа тасралтгүй сайжруулах